

ҮНЭН ЭСВЭЛ ХУДАЛ ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛЖ, ТАЙЛБАР ХИЙНЭ ҮҮ.

Дэлхийн эдийн засаг

- 1) Анчин-цуглуулагч (hunter-gatherer) нь амьтан агнаж, тэжээллэг өвс ургамал түүж иддэг байсан бөгөөд зөвхөн 12 мянган жилийн өмнөх үеийн хүмүүст хамаатай.
- 2) Анчин-цуглуулагч нь байгальтай хамгийн сайн зохицож амьдардаг байсан ба хүн үүссэн түүхийн хугацааны 90 хувийг хамаардаг.
- 3) Хүн төрөлхтнийг carnivore төрлийн амьтан гэж үздэг бөгөөд анчин-цуглуулагч хүн нь зэрлэг амьтантай ижил түвшинд амьдарч байсан.
- 4) 1800 оноос өмнө дэлхийн улс орнуудын нэг хүнд ноогдох орлого ерөнхийдөө адилхан байсан.
- 5) 1800 оноос өмнөх эдийн засгуудад нэг хүнд ноогдох орлогын өсөлт ихээхэн ажиглагдаагүй.
- 6) 1800 онд амьдарч байсан хүн 100 мянган жилийн өмнө амьдарч байсан хүний эдийн засгийн орчноос илүү орчинд амьдарч байсан.
- 7) Мальтусын Урхи нь орлогын өсөлтөд эерэгээр нөлөөлж ирсэн.
- 8) 18-р зуунд Англи зэрэг баян орны язгууртнууд шинэ чулуун зэвсгийн үетэй ижил материаллаг амьдралтай байсан.
- 9) Зүүн болон өмнөд Ази, ялангуяа Япон, Хятадын эдийн засгийн материаллаг амьдрал харьцангуй илүү байсан.
- 10) 1800 онд хүний наслалт 35-45 жил байсан.

ОЛОН СОНГОЛТТОЙ ТЕСТ

- 1) Аль нь Хуучин чулуун зэвсгийн үед хамаарах вэ?
 - a) МЭӨ 5,000 - 10,000
 - b) МЭӨ 2 сая – 8,000
 - c) МЭӨ 12,000 – МЭ 1800
- 2) Аль нь Шинэ чулуун зэвсгийн үед хамаарах вэ?
 - a) МЭӨ 8,000 - 3,000
 - b) МЭӨ 10,000 - 5,000
 - c) МЭӨ 12,000 – МЭ 1800
- 3) Аль нь Шинэ чулуун зэвсгийн үед хамаарах вэ?
 - a) Ан хийх, тэжээллэг ургамал цуглуулах
 - b) Ногоо тарих, жимс түүх, ан хийх
- 4) Шинэ чулуун зэвсгийн үед _____
 - a) хүмүүс ан хийж хүнсээ цуглуулах шаардлагатай болсон.
 - b) суурин амьдрал эрчимтэй хөгжиж соёл иргэншил бүрэлдэж эхэлсэн.
 - c) шинэ ногоо ургамал тарьж, ургуулж, хүнсэндээ

хэрэглэхгүй байсан.

- 5) Аль материаллаг амьдралын боломжийг өөрчилсөн бэ?
 - a) Great divergence
 - b) Industrial Revolution
 - c) Malthusian Trap
- 6) 1820 он гэхэд ____
 - a) дэлхийн ихэнх оронд орлогын хэмжээ өсч тогтворжиж ирсэн.
 - b) цөөн хэдэн орны нэг хүнд ноогдох орлогын хэмжээ тогтмол өсөх хандлагатай болсон.
 - c) зарим оронд орлогын өсөлт огт ажиглагдаагүй.
 - d) дэлхийн ихэнх оронд орлогын хэмжээ нэмэгдэх нь тодорхойгүй байсан.
- 7) Аж үйлдвэрийн хувьсгалаас хамгийн их ашиг тус хүртсэн нь _____ байсан.
 - a) газар болон капиталын эзэд
 - b) боловсролтой чадварлаг хүмүүс
 - c) баян чинээлэг хүмүүс
 - d) ядуус болон ур чадвар дорой хүмүүс
- 8) Үйлдвэрлэлийн гарц ихтэй баян орнууд _____
 - a) тодорхой бараа үйлчилгээг үйлдвэрлэж байсан ч зөвхөн баян давхаргын иргэдэд үр өгөөжтэй байсан.
 - b) их хэмжээгээр бараа үйлчилгээг үйлдвэрлэж, гадаадад экспортолж ашиг олох болсон.
 - c) үйлдвэрлэлийн хэмжээгээ эрс өсгөж, нийгмийн доод давхарга хүртэл хангалттай хүрэлцэхүйц хангалуун амьдралтай болсон.
 - d) Дээрх хариулт бүгд буруу
- 9) Аж үйлдвэрийн хувьсгалын _____
 - a) давуу тал нь нийт орныг хамарч эдийн засгийн өсөлтийг авчирсан.
 - b) үр өгөөж буурай хөгжилтэй орнуудад илүү их бараа бүтээгдэхүүн хэрэглэх боломж төдийлэн олгоогүй.
 - c) үр дүнд эдийн засгийн хөгжил цэцэглэлт бүх нийгэмд ач тусыг хүртээгээгүй.
 - d) Дээрх хариулт бүгд буруу
- 10) Аж үйлдвэрийн хувьсгал _____
 - a) нийгэм доторх тэгш бус байдлыг улам нэмсэн.
 - b) нийгэм хоорондын тэгш бус байдлыг бууруулсан.
 - c) нийгэм доторх тэгш бус байдлыг бууруулсан.
 - d) нийгэм хоорондын тэгш бус байдалд нөлөө үзүүлээгүй.
- 11) Great Divergence _____
 - a) хамгийн баян хүнийг илэрхийлнэ.
 - b) хамгийн ядуу хүнийг илэрхийлнэ.
 - c) баян ядуугийн эрс тэс ялгааг илэрхийлнэ.

d) орлогын хэт их ялгааг илэрхийлнэ.

12) 1800 оноос өмнөх үеийг _____

- a) хүний нөлөөгүй эдийн засаг гэдэг.
- b) хөдөөний эдийн засаг гэдэг.
- c) амьтдын эдийн засаг гэдэг.
- d) амьдралын орчин нөхцөл амьтнаас ялгаагүй байсан гэж үздэг.

13) Санваартан Томас Роберт Мальтус “An Essay on a Principle of Population” зохиолоо хэдэн онд бичиж дууссан бэ?

- a) 1921
- b) 1776
- c) 1820
- d) 1798

14) 1800 оноос өмнө материаллаг амьдралын дэвшил байгаагүй.

- a) Үнэн.
- b) Худал.

15) Аж үйлдвэрийн хувьсгалаас өмнө цөөн тооны элитүүд баян чинээлэг амьдралтай байсан ч 1800 оны дундаж хүний хувьд хуучин болон шинэ чулуун зэвсгийн үеийн өвөг дээдсийнхээ амьдралаас дээрдэхгүй амьдарч байсан





- a) Үнэн.
- b) Худал.

16) Аж үйлдвэрийн хувьсгалын үр дүнд үүссэн шинэ технологийг амархан экспортолж дэлхийн олон орон импортолох боломжтой.

- a) Үнэн.
- b) Худал.

ТОВЧ ХАРИУЛТТАЙ АСУУЛТ

- 1) Аж үйлдвэрийн хувьсгалын ач холбогдлын талаар хэлэлцэнэ үү.
- 2) Аж үйлдвэрийн хувьсгал Хятад, Японд биш яагаад Англид явагдсан бэ?
- 3) Дараах зургуудад тайлбар хийнэ үү.



ҮНЭН ЭСВЭЛ ХУДАЛ ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛЖ, ТАЙЛБАР ХИЙНЭ ҮҮ.

Мальтусын эдийн засгийн логик

- 1800-аад он хүртэл эдийн засгийн амьдралын хувьд төрөлтийн хувь нас баралтын хувиас бага байсан.
- 1800 оны хөдөө аж ахуйн нийгэмд амьдарч байсан дундаж хүний эд материалын хэрэглээний түвшин эртний омгийн хүний хэрэглээнээс арай илүү ч шинэ чулуун зэвсгийн үеийн түвшингээс бага байсан.

Мальтусын тэнцвэр

- Эмэгтэй хүн насан туршдаа 15 хүүхэд төрүүлэх боломжтой ба доод тал нь 12 хүүхэд төрүүлэх шаардлагатай.
- 1800 оноос өмнө нэг эмэгтэйн төрүүлсэн хүүхдүүдийн хоёр нь насанд хүртлээ амьдардаг байсан.
- Дэлхийн хүн ам 100 мянган жилийн өмнө 100 мянга байсан ба 1800 он болоход 770 саяд хүрсэн.
- Мальтусын модел урт хугацаан дахь хүн амын төрөлт нас баралтыг судалдаг.
- 1300 болон 1800 оныг харьцуулахад Баруун Европт Франц улс хамгийн бага хүн амтай байсан.
- Аливаа нийгэмд амьдралын чанар сайжрахын хэрээр нас баралтын хэмжээ буурч, цааш хүн амын өсөлтийн нэгэн шалтгаан болдог ба амьдралын чанар улам дээшилдэг.
- Төрөлтийн хэмжээ нь мянган хүн тутамд хэдэн хүүхэд байгааг илэрхийлдэг.
- Наслалтыг тооцоход жишээ нь нас баралтын хэмжээ 33/1000 бол насалт 50 жил байна.

ОЛОН СОНГОЛТТОЙ ТЕСТ

- Тогтмол хүн амтай бол ____
a) төрөлтийн хэмжээ бага байна.
b) хүмүүс урт насална.
c) төрөлт болон нас баралтын хэмжээ ижил байна.
- Аж үйлдвэржилтээс өмнөх нийгэмд ____
a) эд материал хомсдож хүмүүс өлсгөлөнд амьдарч байсан.
b) зөвхөн төрөлтийг хязгаарласнаар урт наслах боломжийг нэмэгдүүлж байсан.
c) нас баралт бага байсан учир төрөлт ч их байсан.
- 1650 онд Англид тариаланч хүний цалин ____
a) 5 кг буутайтай тэнцүү байсан.
b) өдрийн биологийн минимум шаардлагатай калорид

хүрдгүй байсан.

- 1400 онд 3.6 кг-тай тэнцүү байсан ба дээрх онд 4.09 кг байсан.
- Орлого амь зуулгын түвшинд хүрэхэд ____
a) хүмүүс ядуусын эгнээнд орно.
b) хүн амын өсөлт зогсоно.
c) нас баралт ихэснэ.
 - Аж үйлдвэржилтээс өмнөх нийгэм ____
a) амь зуулгын түвшинд байсан.
b) эдийн засгийн хэт зогсонги өсөлттэй байсан.
c) өлсгөлөнд нэрвэгдээгүй байсан.
 - Орлого үргэлж амь зуулгын түвшинд буцаж ____
a) өлсгөлөнд нэрвэгдэх шалтгаан болдог.
b) хүн ам ба нэг хүнд ноогдох орлогын хооронд сөрөг хамааралтай байдаг.
c) харин зарим оронд орлогын өсөлт огт ажиглагдсан.
 - Хүн ам өсөхийн хэрээр орлого буурдаг гэсэн санааг ____
a) Мальтус дэвшүүлсэн ба орлогын бууралтын хууль гэж нэрлэдэг.
b) Дэвид Рикардо үр ашиг буурах хууль гэж эдийн засгийн ухаанд нэвтрүүлсэн.
c) Мальтус үр өгөөж буурах хууль гэж боловсруулсан.
d) Дээрх хариулт бүгд буруу.
 - Аливаа үйлдвэрлэлд ____
a) үр өгөөж буурах хууль үргэлж үйлчилдэг.
b) хөдөлмөр заавал ашиглахгүй байж болно.
c) нэг хүчин зүйлийг тогтмол байлгахад бусад хүчин зүйлийн хэмжээг ихэсгэхэд гарц нь тогтмол нэмэгддэг.
d) Дээрх хариулт бүгд буруу.
 - Аж үйлдвэржилтээс өмнө үйлдвэрийн гол хүчин зүйл ____ байсан.
a) капиталын өсөлт байсан.
b) Үйлдвэрийн цор ганц үндсэн хүчин зүйл хөдөлмөр байсан.
c) нийлүүлэлт хязгаарлагдмал газар байсан.
d) Дээрх хариулт бүгд буруу.
 - Үр өгөөж буурах хуулийн үндсэн санааг анх ____
a) капиталын хомсдолтой холбон тайлбарласан.
b) газрын нийлүүлэлт хязгаарлагдмал учир газрыг жишээ болгон авсан.
c) үйлдвэрлэлийн үндсэн орцуудын хүрээнд тайлбарласан.
d) технологийн хуваарийн хүрээнд дэвшүүлсэн.
 - Хүн ам өсөхөд ____

- a) баян ядуугийн ялгаа нэмэгдэнэ.
- b) эдийн засаг уналтанд орно.
- c) нэг хүнд ноогдох материаллаг хэрэглээний дундаж өснө.
- d) нэг хүнд ноогдох материаллаг хэрэглээний дундаж буурна.

Төрөлт, нас баралтын хэмжээ

- 12) Төрөлт, нас баралтын хувь хэмжээ нийгэм бүрт харилцан адилгүй бөгөөд цаг хугацааны явцад хувьсан өөрчлөгдөж байдаг
- a) Үнэн.
 - b) Худал.
- 13) Төрөлт нь нас баралтын хувиас илүү байвал _____
- a) богино хугацаанд бага төрөлттэй байна.
 - b) хүн ам өсч нэг хүнд ноогдох орлогын хэмжээ өөрчлөгдөхгүй.
 - c) богино хугацаанд илүү их төрөлттэй байх ба хүн ам өсч нэг хүнд ноогдох орлогын хэмжээ буурч нас баралтын хэмжээ дахин нэмэгдэж төрөлт ба нас баралт тэнцвэржинэ.
 - d) Дээрх хариулт бүгд буруу
- 14) Хэрвээ нас баралтын хэмжээ нэмэгдэж төрөлтийн хэмжээнээс илүү гарвал _____
- a) хүн амын өсөлт удааширч нэг хүнд ноогдох орлого өсөх ба шинэ тэнцвэрт хүрэх болно.
 - b) хүн амын өсөлт тогтворжиж нэг хүнд ноогдох орлого буурах ба шинэ тэнцвэрт хүрэх болно.
 - c) хүн амын өсөлтөд нөлөөгүй ч нэг хүнд ноогдох орлого өсөх ба шинэ тэнцвэрт хүрэх болно

- 15) Мальтусын үзэлд анагаах ухааны дэвшил, хувь хүний ариун цэвэр, энх тайван байдал зэргийг мөн наслалтад нөлөө үзүүлэхгүй материаллаг амьдралын стандартыг бууруулдаггүй гэж үздэг.

- a) Үнэн.
- b) Худал.

- 16) Аж үйлдвэрийн хувьсгалын үр дүнд үүссэн шинэ технологийг амархан экспортолж дэлхийн олон орон импортлох боломжтой.

- a) Үнэн.
- b) Худал.

Технологийн өөрчлөлт

- 17) Бодит орлогын хэмжээ төрөлт ба нас баралтын харьцаанаас хамаардаг бол хүн амын хэмжээ хүн ам ба бодит орлогын харьцаанаас хамаардаггүй.
- a) Үнэн.

- b) Худал.


- 18) Технологийн өөрчлөлт хүн амын өсөлтийн шалтгаан болж шинэ тэнцвэрт хүрнэ.

- a) Үнэн.
- b) Худал.


ТОВЧ ХАРИУЛТТАЙ АСУУЛТ

- 1) Аливаа нийгэмд технологийн дэвшил зогсонги байхад ажилчдын тоог нэмэгдүүлснээр нэмэлт нэгж ажилчин бүрийн ахиу гарц буурна гэсэн санааг тайлбарлана уу.
- 2) Мальтусын үзсэнээр төрөлтийн хэмжээ нэмэгдэх нь бодит орлогын хэмжээг бууруулна гэсэн санааг тайлбарлана уу.
- 3) Дараах зургуудад тайлбар хийнэ үү.


Зураг 1.




Зураг 2.




Зураг 3.




Зураг 5.



Зураг 4.



Зураг 6.



ҮНЭН ЭСВЭЛ ХУДАЛ ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛЖ, ТАЙЛБАР ХИЙНЭ ҮҮ.

Мальтусын эдийн засгийн амьдралын стандарт

- 1) Дэлхийн эдийн засгийн түүхэнд 1800 оноос өмнөх цалингийн мэдээлэл хангалттай байдаг ба Английн хувьд 1200 оноос хойших цалин болон үнийн өөрчлөлтийн мэдээлэл байдаг.
- 2) Бодит цалин гэдэг нь татвар, хураамжийг төлсны дараа бодитоор гар дээр авч буй мөнгөны хэмжээ юм.

1800 оноос өмнөх бодит цалин

- 3) Английн барилгачин болон тариачдын 1209-1809 оны бодит цалингийн хэмжээнээс үзэхэд 1300-1450 оны хооронд бодит цалин өсөлтгүй байсан.
- 4) 1800 оноос өмнөх үеийн бодит цалин тооцоход ажилчны зардлын бүрдэлдэхүүнд хүнс, орон байр, халаалт, гэрэл, ариун цэврийн саван зэргийг тооцсон.
- 5) 1800-аад онд Английн тариачны орлогын 2/3 хүнсий хэрэглээнд ноогддог байсан.
- 6) 1200-1800 оны хооронд 600 жилийн хугацаанд Англид бодит цалингийн өсөлт мэдэгдэхүйц ажиглагдаж ирсэн.
- 7) Аж үйлдвэржилтээс өмнөх ажилчны амьдралын материаллаг чанар өнөөгийн буурай орнуудынхаас хэт доогуур байсан.
- 8) 700 саяас илүү хүн амтай улсууд аж үйлдвэржилтийн үеийн Английн дундаж орлогоос доогуур байсан.
- 9) 1950 онд хөгжиж буй орнуудын хүн амын наслалт 40 жил байсан ба 2000 онд 75 болж нэмэгдсэн.
- 10) Аж үйлдвэржилтийн үеийн амь зуулгын цалин өнөөгийн цалингаас доогуур байсан.

ОЛОН СОНГОЛТТОЙ ТЕСТ

- 1) 1800 оноос өмнөх _____
 - a) цалингийн мэдээлэл нийгмийн технологийн хөгжил цалинг тодорхойлох хүчин зүйл болдогийг харуулсан.
 - b) Английн цалин эртний Бабилонь цалингаас бага зэрэг өндөр байсан.
 - c) амьдралын материаллаг байдлыг харьцуулахад нэг хүнд ноогдох хүнсний уургийн хэмжээг ашиглах боломжтой.
- 2) Пруссийн статистикч Эрнст Энгел (1821-1896) _____
 - a) капиталын мөн чанарын талаар судалгаа хийсэн.
 - b) Германы нэг хүнд ноогдох орлогын хэмжээг нарийвчлан судалсан.

- c) Германы ажилчин ангийн өрхийн төсвийг судалж нэгэн чухал хамаарлын нотолгоог санал болгосон.

- 3) Өрх ядуу байхын хэрээр орлогын дийлэнх хүнсэнд зарцуулагддаг.
 - a) Үнэн.
 - b) Худал.
- 4) Хамгийн буурай хөгжилтэй нийгэмд нийт зардлын _____ хүнсэнд зарцуулдаг.
 - a) 60-80 хувийг
 - b) 80-аас их хувийг
 - c) дийлэнх хувийг
- 5) Ядуусын орлого нэмэгдэхэд _____
 - a) өндөг, сүү, төмс хүнсэнд ихээр хэрэглэдэг.
 - b) цардууллаг хүнсний хэрэглээг нэмдэг.
 - c) илүү илчлэг өндөртэй хүнс хэрэглэдэг.
- 6) Эрүүл мэндийн түвшин _____
 - a) цардууллаг хүнсний хэрэглээнээс хамаардаг.
 - b) болон биеийн өндөр хооронд хамааралтай гэж үздэг.
 - c) муу байх нь наслалтыг богиносгодог.
- 7) Түүхэн явцад _____
 - a) цардууллаг хүнс ихээр хэрэглэж ирсэн Азийн хүмүүс биеийн өндрөөр анчин цуглуулагч хүмүүсээс өндөр байсан.
 - b) Европ хүмүүс биеийн өндрөөр хамгийн илүү байсан.
 - c) дэлхийн хүмүүсийн дундаж өндөр 170 байсан.
 - d) Дээрх хариулт бүгд буруу.
- 8) Антропологиин олдвор араг ясны мэдээллээс үзэхэд _____
 - a) анчин-цуглуулагч хүмүүс намхан байсан.
 - b) суурин, хөдөө аж ахуйн нийгэмд амьдралын чанар сайжирч ирсэн.
 - c) Анчин-цуглуулагч хүмүүсийн амьдралын стандарт аж үйлдвэржилтийн эхэн үеийнхээс дээгүүр байсан.
 - d) Дээрх хариулт бүгд буруу
- 9) Аж үйлдвэржилтийн хувьгал _____
 - a) 1760-1820 оны хооронд явагдсан.
 - b) 1600-1800 оны хооронд явагдсан.
 - c) 1798 онд эхлээд 1800 онд эрчимтэй явагдсан.
 - d) Дээрх хариулт бүгд буруу
- 10) Аж үйлдвэрийн хувьсгал явагдсанаар _____
 - a) ур чадвар доогуур ажилчдын ажлын цаг харьцангуй тогтсон.
 - b) барилгачин болон тариаланчид ажлын урт цагаар ажиллах нь хэвээр байсан.
 - c) нэг хүнд ноогдох ажлын цаг буурсан.

11) Мальтусын эдийн засагт _____

- a) ажилчин жилд 210 өдөр ажилладаг байсан.
- b) ажилчин харьцангуй бага цагаар ажилладаг байсан.
- c) ажилчин жилд 2100 цаг ажилладаг байсан.
- d) Дээрх хариулт бүгд буруу.

12) “Аж үйлдвэрийн хувьсгал” явагдаж ажилчид жилийн 3200 цаг ажиллах болсон ба эдийн засгийн сайхан байдал дээшилсэн.

- a) Үнэн.
- b) Худал.

13) Хөдөлмөрийн орцыг нэмэгдүүлэх нь бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх ба богино хугацаанд төрөлтийн хувь нас баралтын хувь тэнцвэржиж хүн амын өсөлт тогтворжино.

- a) Үнэн.
- b) Худал.

14) Хүн амын өсөлт хангалттай явагдсаны дараа эдийн засагт шинэ тэнцвэр тогтож бодит орлого өмнөх түвшиндээ хүрэх боловч өмнө нь 2100 цаг ажиллаж авдаг байсан цалинг 3200 цаг ажиллаж авна.

- a) Үнэн.
- b) Худал.


15) 1800 оны хөдөө аж ахуйн нийгэмд хөдөлмөрийн нэг цагт үйлдвэрлэх калорийн хэмжээ цуглуулагч болон байгалийн ургамал, жимс хураагч нийгмээс бага байсан.

- a) Үнэн.
- b) Худал.


ТОВЧ ХАРИУЛТТАЙ АСУУЛТ

- 1) Амьдралын материаллаг чанар гэсэн ойлголтыг тайлбарлана уу.
- 2) Бодит цалингийн талаар тайлбарлана уу.
- 3) Эдийн засгийн түүхчид амьдралын материаллаг чанарыг тодорхойлох гэсэн аргуудын талаар хэлэлцэнэ үү.
- 4) Дараах зургуудад тайлбар хийнэ үү.


Зураг 1.




Зураг 2.




Зураг 3.



Зураг 4.



Зураг 5.



ҮНЭН ЭСВЭЛ ХУДАЛ ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛЖ, ТАЙЛБАР ХИЙНЭ ҮҮ.

Марко Поло ба Торгоны зам

- 1271 онд Марко Поло аав, авга ахын хамт Ром хотоос Их Юань Улсыг зорьсон.
- Марко Пологийн гэр бүл Улаан тэнгист Крым болон Константинополын хооронд худалдаа хийдэг байжээ.
- Аялалын зорилго Их Хаанд Христийн сайн мэдээг хүргэх байсан ба тэд Европоос азид хөл тавьсан анхны худалдаачид байсан.
- Пологийнхэн Европоос дорно зүгт аялсан учир тэрхүү замын дагуу дундад зууны эдийн засгуудыг холбосон чухал зам үүссэн.
- Тухайн үед эдийн засгууд өнөөгийн дэлхийн эдийн засаг шиг нягт холбогдоогүй, тус бүрийн мөнгө, хөрөнгө оруулалтын бүтэцтэй, эд баялаг худаалдаачдын гарт төвлөрсөн байсан.
- 400-аас 1400 онд Энэтхэг хамгийн баян эдийн засаг байсан.
- Өнөөгийн Хятадын Оростой хиллэх хилийн ойролцоо Кашгар хот Торгоны замаар аялах худалдаачин, жинчидын хувьд буудаллаад өнгөрөх чухал газар байсан ба Ойрх Дорнод, Хар тэнгисийн бүс нутгийг Энэтхэг, Хятадтай холгож байв.
- Торгоны зам Азийн олон орнуудыг худалдааны системд холбосон чухал зангилаа болж байв.
- Поло торгоны замын баруун хязгаарт хүрч Их хааны эд баялагийг гайхан биширсэн тэмдэглэлүүд үлдээжээ.
- Дайду хотын худалдаа, наймааны талаар бичиж үлдээсэн.

ОЛОН СОНГОЛТТОЙ ТЕСТ

- Марко Пологийн тэмдэглэлд худалдааны замын сүлжээг (web of trade routes) тэмдэглэн үлдээгээгүй нь аль вэ?
 - Хятад, Зүүн өмнөд Ази, Энэтхэг
 - Хятад, Төв Ази, Ойрх Дорнод, Европ
 - Хятад, Энэтхэг, Америк, Европ
- 13-р зуунд Монголчууд Хятадыг эзэлснээр _____
 - анх Торгоны зам үүссэн.
 - торгоны зам илүү аюулгүй болсон.
 - Азийн орнууд нягт худалдаа хийх болсон.
- Дараахаас аль зөв биш вэ?
 - Торгоны замын хоёр тал Хятад, Европ 1000 жилийн дараа дахин холбогдсон байдаг.
 - Европын эдийн засгийн хөгжил Хятадын эдийн засагтай харьцуулахад харьцангуй ижил байсан.
 - Технологийн хувьд Хятад маш илүү байсан ч газар

тариалан, төмрийн үйлдвэрлэл зэргээр хоцрогдмол байсан.

- Европын хувьд олон жижиг улсуудаас бүрдэж байсан бол Азид Монголын их гүрнүүдийн дараа бий болсон томоохон хаант улсууд байв.
 - Үнэн.
 - Худал.
- Марко Пологийн аялалаас хойш _____ дараа _____ оноос эхлэн Европт улс төр, эдийн засгийн өөрчлөлт, тэлэлт явагдаж эхэлсэн.
 - 200 жилийн, 1450-аад
 - 100 жилийн, 1350-аад
 - 600 жилийн, 1850-аад
- Дундад зуунаас хойш Хятад торгоны үйлдвэрлэл эрхэлдэг цорын ганц үндэстэн байсан дэлхийн торгоны монопол байсан.
 - Үнэн.
 - Худал.
- Дундад зууны эхээр Сирийн худалдаачин торгоны хүр хорхойг Хятадаас нууцаар авч гарснаар Ойрх дорнодод мөн торгоны үйлдвэрлэлтэй болсон.
 - Үнэн.
 - Худал.
- Хятад 900 онд цаасан мөнгийг анх гаргасан гэж үздэг.
 - Үнэн.
 - Худал.
- Европт 16-р зуун хүртэл цаасан мөнгийг нийтээр хэрэглэдэггүй байсан.
 - Үнэн.
 - Худал.
- Цаасан мөнгө гарснаар _____
 - Мөнгөны эргэлтийн хурд нэмэгдсэн.
 - Төр мөнгөны зохицуулалтыг хийх болсноор татварын орлого нэмэгдэж улсын баялаг нэмэгдсэн.
 - Дээрх хариулт бүгд зөв.
- Газар тариалан хөгжсөнөөр _____.
 - Хүн ам өсч хотжилт эрчимтэй явагдсан.
 - Хөдөө аж ахуйн бус салбарууд ихээр хөгжсөн.
 - Далайн худалдаа ихээр хийх болсон.
 - Дээрх хариулт бүгд зөв
- 14-зуунд Хятадын усан онгоц _____ тон, Европын усан онгоц _____ тон тээвэрлэдэг байсан.
 - 400, 60

- b) 2000, 600
c) 3000, 600
- 13) 14-р зууны Хятадад хамаарахгүй нь аль вэ?
a) Төмрийн үйлдвэрлэл
b) Экспортын бараа
c) Санхүүгийн шинэчлэл (цаасан мөнгө, засгийн газрын санхүү)
d) Халуун ногоо
- 14) Энэтхэг улсад даавууны үйлдвэрлэл асар их хөгжсөн.
a) Үнэн.
b) Худал.
- 15) Даавуу чанарын хувьд доогуур байсан ч _____ эрэлт ихтэй байсан тул зөвхөн дотоодын зах зээлээ хангахаас гадна эдгээр бүс нутаг руу экспортолдог байсан.
a) Египет, Хятад, Африк, Ойрх Дорнодод
b) Зүүн Өмнөд Ази, Зүүн Африк, Ойрх дорнодод
c) Зөвхөн Ази болон Ойрх Дорнодод
- 16) Энэтхэг _____ Энэтхэг далайн бүс нутаг даяар экспортолдог байсан.
a) бөс бараа, даавууг
b) тариа буудай, будааг
c) Дээрх хариулт бүгд буруу
- 17) Энэтхэгийн эдийн засаг экспортоос давсан импорттой бие даасан байжээ.
a) Үнэн.
b) Худал.
- 18) Энэтхэгийн чухал импортын бараа Хятадын болор, Ойрх дорнодын зэс байсан.
a) Ойрх Дорнодын алт, Хятадын зэс
b) Ойрх дорнодын зэс, Хятадын болор
c) Дээрх хариулт бүгд буруу
- 19) Энэтхэг өөрийн үйлдвэрлэлийн дутагдалтай байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 20) 14-р зуун гэхэд зүүн Энэтхэгээс Хятадын өмнөд тэнгис хүртэл далайн тээвэрлэлтийг _____ давамгайлан хийж байсан.
a) Энэтхэгчүүд
b) Арабууд
c) Хятадууд
d) Дээрх хариулт бүгд дуруу
- 21) _____ баруун Энэтхэгээс Ойрх Дорнод Африк хүртэл тээврийг хийдэг байсан.
a) Энэтхэгчүүд
b) Арабууд
c) Хятадууд
d) Дээрх хариулт бүгд дуруу
- 22) Энэтхэгийн лалын шашинтай Gujarat _____ далайн тээвэрт тодорхой байр эзэлдэг байсан.
a) далайн тээвэрт тодорхой байр эзэлдэг байсан
b) Энэтхэгийн дотоодын эхэс дээдсийн тансаг хэрэглээний импортын гол бүс нутаг байсан.
c) Африкийн худалдаа, Өмнөд Энэтхэгийн транзит худалдаанд оролцдог байсан.
d) Дээрх хариулт бүгд зөв.
- 23) 15-р зуун гэхэд Арабын далайн тээвэр, гол боомт хотуудад хэт давамгайлж Баруун Энэтхэгийн Хятадтай хийх далайн тээврийн худалдааг шахан гаргасан.
a) Үнэн.
b) Худал.
- 24) 15-р зуунд Хятад Энэтхэгтэй хийх худалдаа эрс багассанаар далайн худалдаанд эдгээр улсаас өөр улсын худалдаачид орж ирэх нөхцөл бүрдсэн.
a) Үнэн.
b) Худал.
- 25) Ойрх Дорнод зүг бүртээ худалдаа хийх таатай байршилд байгаагүй.
a) Үнэн.
b) Худал.
- 26) Худалдааны гол замууд ихээхэн өөрчлөгдөөгүй ч ихэнх тохиолдолд Монголчуудын байлдан дагуулалтаас болж өөрчлөгдөж байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 27) Монголчууд дундад зууны үед Ойрх Дорнодыг дэлхийн эдийн засгаас холдуулсан гэж үздэг.
a) Үнэн.
b) Худал.
- 28) 13-р зуунд Монголчууд Ази, Европыг холбосон их гүрнүүдийг байгуулсны дараа дэлхийн худалдааны хөгжлийг саатуулсан.
a) Үнэн.
b) Худал.
- 29) Монголчууд газар орноо тэлэх, худалдааг өргөжүүлэх бодлого баримталдаг байсан.
a) Үнэн.

b) Худал.

30) Торгоны замаар жин тээвэрлэж худалдаа хийх улам аюулгүй болсон.

a) Үнэн.

b) Худал.

31) 13-р зуунд Европт загалмайтны улсууд унахад Италийн худалдаачид Египетээр явах замыг ихээр ашиглах болж Энэтхэгийн далайгаар явах ачааг эрс нэмэгдүүлсэн.

a) Үнэн.

b) Худал.

32) 1291-ээс 1517 он хүртэл Европоос зүүн зүг рүү хийх худалдааны 80 хувийг Египет дангаараа хянадаг байсан.

a) Үнэн.

b) Худал.

33) Венец газар тариалан дээр тулгуурласан эдийн засагтай байсан.

a) Үнэн.

b) Худал.

34) Хятад, Энэтхэг, Ойрх Дорнод болон Европ гэсэн эдийн засгийн үндсэн 4 том тойрог байсан.

a) Үнэн.

b) Худал.

ТОВЧ ХАРИУЛТТАЙ АСУУЛТ

- 1) Торгоны замын талаар хэлэлцэнэ үү.
- 2) 13-р зууны дэлхийн эдийн засгийн онцлогийн талаар хэлэлцэнэ үү.
- 3) Тухайн үеийн эдийн засгуудын технологийн талаар ярилцана уу.
- 4) Цаасан мөнгөний онцлог, ач холбогдлын талаар ярилцана уу.
- 5) Монголчуудын байлдан дагуулалт, эдийн засгийн ач холбогдлын талаар хэлэлцэнэ үү.

ҮНЭН ЭСВЭЛ ХУДАЛ ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛЖ, ТАЙЛБАР ХИЙНЭ ҮҮ.

Тахлын эдийн засагт үзүүлэх нөлөө

- 1) Хар үхэл бол түүхэн дэх хамгийн аймшигт тахлуудын нэг байсан бөгөөд дундад зууны эхэн үеийн нийгэм, эдийн засагт гүн нөлөө үзүүлсэн.
- 2) Хар Үхэл бол 14-р зууны сүүл үед зөвхөн Европын ихэнх нутагт дэгдсэн аймшигт цар тахал юм.
- 3) Хар үхэл тахлыг Библид дурьдсан сүйрлийн дөрвөн морьтны үхлийн морьтонтой холбож тайлбарлаж байсан.
- 4) 400-1400 он хүртэл дэлхийн цар уур тогтмол сэрүүсэж ургац муудсан ба энэ үеийг бага мөстлөгийн үе гэж нэрлэдэг.
- 5) 14-р зууны сүүл үеийн цаг уурын өөрчлөлт ургац хураалтад сөрөг нөлөөлж Европт их өлсгөлөн үүсэх шалтгаан болсон.
- 6) Хүмүүс хүнс тэжээлийн дутагдалд орох түвшинд хүрээгүй ч хоорондоо дайтаж өлсгөлөнг газар авхуулсан.
- 7) Крымийн хойг дээрх Каффад болсон Монголчуудын тулаан энэхүү тахлыг Европ авчирсан гэж үздэг.
- 8) Хар үхэл тахал дэгдэхээс өмнө Европт харьцангуй тайван байсан ба эдийн засаг тогтвортой байсан.
- 9) Дундад зуун буюу ойролцоогоор 400-1400 оны эхэн үед цаг уурын дулаарал явагдаж ургацын гарцыг нэмэгдүүлэх таатай орчин бүрдсэн.
- 10) Тухайн үеийн технологийн түвшинд гарцыг хэмжээг нилээд нэмэгдүүлдэг байсан.

ОЛОН СОНГОЛТТОЙ ТЕСТ

- 1) Зарим жилд ургац сайтай, зарим үед ургац муу байсан ба ____
 - a) Европт нэг хүнд ноогдох орлого амь зуулгын түвшнээс үргэлж доогуур байсан.
 - b) Европт үргэлж хүнсний хомсдолтой байжээ.
 - c) гарцыг багаар нэмэгдүүлж байсан.
- 2) Европт хэт өлсгөлөнд оролгүй хүнсний хэрэгцээ ____
 - a) амь зуулгын түвшинд хангаж ирсэн тул 14-р зуунаас өмнө хүн ам нилээд өссөн.
 - b) амь зуулгын түвшинд хүрэхгүй байж 14-р зуунаас өмнө хүн ам өсөөгүй.
 - c) Азийн орнууд нягт худалдаа хийх болсон.
- 3) Дараахаас аль зөв биш вэ?
 - a) Хүн ам өссөнөөр илүү их хүнсний хэрэгцээ үүссэн.
 - b) Өмнө ашиглаж байсан газруудыг илүү ихээр ашиглах болсноор.

- c) Газрын гарц нэмэгдсэн ч хүнсний илүүдэл гардаггүй байсан.

d) Дээрх хариултауд бүгд зөв.

- 4) 14-р зууны эхний арван жилд цаг агаар сэрүүсэж, хур тунадас ихээр орох болж хөдөө аж ахуйд хямрал нүүрлэсэн.
 - a) Үнэн.
 - b) Худал.
- 5) 1309 онд анх баруун ____ ургац хураалт амжилтгүй болсон.
 - a) зүүн өмнөд Францад
 - b) баруун өмнөд Англид
 - c) баруун өмнөд Германд
- 6) 1310 онд Европ даяар хүйтэн бороо орох нь харьцангуй буурсан.
 - a) Үнэн.
 - b) Худал.
- 7) Цаг агаарын энэ үзэгдэл цаашид намжиж улмаар 1315-1318 оны хооронд тогтуун болсон.
 - a) Үнэн.
 - b) Худал.
- 8) Европт хэт их бороо орсний улмаас 1316 он гэхэд ургацынхаа талыг авах боломжгүй болсон.
 - a) Үнэн.
 - b) Худал.
- 9) Эдийн засгийн бүтээмжийн хувьд ургац сайтай жилд ч Европ тивийг хангахад хүрэлцээтэй байсан.
 - a) Үнэн.
 - b) Худал.
- 10) Цаг агаар сэрүүссэний улмаас ____
 - a) зарим төрлийн хүнсний ногоог огт тариалах боломжгүй болсон.
 - b) ургацын гарц муудаж илчлэг шим тэжээл буурсан.
 - c) Дээрх хариулт бүгд зөв.
- 11) Газар тариалан хөгжсөнөөр ____ .
 - a) зарим төрлийн хүнсний ногоог огт тариалах боломжгүй болсон.
 - b) ургацын гарц муудаж илчлэг шим тэжээл буурсан.
 - c) Далайн .
 - d) Дээрх хариулт бүгд зөв
- 12) Европын Их Өлсгөлөнгийн үе ____ оны хооронд байсан.
 - a) 1315-1318
 - b) 1309-1314
 - c) 1348-1352

1315-1317

- 13) Их Өлсгөлөнгийн улмаас Европын хүн амын 10 хувиар буурсан.
a) Үнэн.
b) Худал.
- 14) Ургацын гарц эрс муудахын зэрэгцээ мал аж ахуйн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж эхэлсэн.
a) Үнэн.
b) Худал.
- 15) Үүний улмаас малын нийлүүлэлт эрс өсч үнэ буурах шалтгаан болсон.
a) Үнэн.
b) Худал.
- 16) 1322 он хүртэл Европын хөдөө аж ахуй хүн амын хүнсний хэрэгцээг хангаж чадаагүй. 1340-өөд он болтол өлсгөлөнд нэрвэгдсэн хэвээр байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 17) _____ улмаас махны нийлүүлэлт буурч олон хүмүүс өлсгөлөнгөөр үхсээр байсан.
a) Малын тахлын
b) Хүнсний хомсдолын
c) Дээрх хариулт бүгд зөв.
- 18) Их Өлсгөлөнгөөс амьд үлдэгсэд _____
a) үр тариаг худалдаж авахад бага үнэ төлөх болсон.
b) шим тэжээлийн гүн дутагдалд орсон.
c) Дээрх хариулт бүгд зөв.
- 19) Өлсгөлөн намжиж ирэхэд _____
a) буудайны үнэ буурч эхэлсэн.
b) махны үнэ нэмэгдэж эхэлсэн.
c) Дээрх хариулт бүгд буруу
- 20) Европын худалдаачид ялангуяа _____ дорноос авчирсан хямд буудайгаар Европыг хангасан.
a) Англи худалдаачид
b) Франц худалдаачид
c) Португал худалдаачид
d) Дээрх хариулт бүгд дуруу
- 21) Дундад зууны үеийн ихэнх дайн элит язгууртнуудын цөөн цэргийн хүрээнд ихэвчлэн зун болдог байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 22) Хүлэг баатрууд байлддаг байсан учир хүн амд

нөлөө ихтэй байсан.

- a) Үнэн.
b) Худал.
- 23) Европт _____ оноос эхлэн 15-р зууны төгсгөл хүртэл үргэжилсэн олон дайн тулаан болсон.
a) 1309
b) 1348
c) 1337
d) 1310
- 24) 14, 15-р зуунд үргэжилсэн дайны хувьд тариалан, талбай, малын бэлчээр зэрэг бүхий л газрыг хамран тулаан хийсэн.
a) Үнэн.
b) Худал.
- 25) Хүлэг баатар, тулаан зэрэг ажил мэргэжил болж ирсэн тул дайныг аль болох хурдан дуусгах сонирхол их байжээ.
a) Үнэн.
b) Худал.
- 26) 14-р зуунд Европт ургацаа алдаж, өлсгөлөнд нэрвэгдэж, дайн тулаан, иргэний бослогууд дууссаны дараа хүн ам цөөрч гэнэт тахал гарсан.
a) Үнэн.
b) Худал.
- 27) Хар Үхэл нэртэй тахал анх Каффад дэгдсэн.
a) Үнэн.
b) Худал.
- 28) Европ тив Их Өлсгөлөнд нэрвэгдсэнээс хойш 10 жилийн дараа, 100 жилийн дайн Flanders-т үргэлжилж байхад алс хол Хятадын өмнөд хэсэгт аймшигт тахал дэгдэж байв.
a) Үнэн.
b) Худал.
- 29) 1330-аад онд Хятадын Хобей зэрэг зарим хотуудын хүн амын 60 хувь тахлаар үхсэн гэсэн баримт байдаг.
a) Үнэн.
b) Худал.
- 30) _____ он гэхэд хүн амын 2/3 тахлаар үхсэн гэх тооцоо байдаг.
a) 1340
b) 1351
c) 1348
d) 1337
- 31) Хятадын мэргч амьтдын бөөсөөр дамжин

халдварладаг тахал харх ихтэй Хятадын өмнөд хэсийн хотуудад ихээр тархсан.

- a) Үнэн.
- b) Худал.

32) Хятадууд Ази даяар болон Торгоны зам дагуу худалдаа хийхэд агуулах саванд харх үүрлэн тээвэрлэгдэж өрнийг дорнотой холбох зам дагуу тархсан.

- a) Үнэн.
- b) Худал.

33) 14-р зууны эхээр Монголын цэрэг тахлыг анх Хятадын Хобей хотонд авчирсныг нотолсон.

- a) Үнэн.
- b) Худал.

34) 1345 онд Хар Үхэл тахал Каффад хүрсэн ба цааш тээвэрлэгдэн Газар дундын тэнгисийн боомтууд руу очсон.

- a) Үнэн.
- b) Худал.

35) Хар Үхэл тахлын хамгийн хүнд хэлбэр аль вэ?

- a) Bubonic
- b) Pneumonic
- c) Septicemic

36) Хар Үхэл тахал эх газраар харх, тэжээмэл мал амьтан, ноосон даавуу зэргээр дамжин тархаагүй байх магадлалтай.

- a) Үнэн.
- b) Худал.

37) Хар Үхэл тахал Европт маш хурдтай тархаж Европын хүн амын 50 хувийг устгасан гэж тооцдог.

- a) Үнэн.
- b) Худал.

38) Ойрх Дорнодод Александриа болон Каир хотуудыг нэрвэж Египетын хот суурин газрын хүн амын тал орчмыг устгасан (1347-1348).

- a) Үнэн.
- b) Худал.

39) Дундад зуунд Хар Үхэл тахал, Евразид дэгдэж Африк болон Хойд Америкт хүрээгүй.

- a) Үнэн.
- b) Худал.

40) Аймшигт тахлын дараа газар дээр ажиллах хөдөлмөрийн үнэ цэн буурч аж ахуй эрхлэх ур

чадвартай худалдаачдын нөлөө нэмэгдэж ирсэн.

- a) Үнэн.
- b) Худал.

ТОВЧ ХАРИУЛТТАЙ АСУУЛТ

- 1) Хар Үхэл тахал дэгдэхээс өмнөх Европын нөхцөл байдлын талаар хэлэлцэнэ үү.
- 2) Хар Үхэл тахлын нийгэм, эдийн засгийн нөлөөний талаар хэлэлцэнэ үү.
- 3) Тахлын эдийн засагт үзүүлэх шууд нөлөөний талаар хэлэлцэнэ үү.
- 4) Цаг уурын өөрчлөлт дундад зууны Европын эдийн засагт хэрхэн нөлөөлсөн талаар хэлэлцэнэ үү.
- 5) Хар Үхэл тахлын дараах нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн талаар хэлэлцэнэ үү.

ҮНЭН ЭСВЭЛ ХУДАЛ ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛЖ, ТАЙЛБАР ХИЙНЭ ҮҮ.

14-р зууны сүүл үеийн нэгдэл ба монопол

- 1) Хар Үхэл тахлын улмаас Европт хүн амын тоо эрс багасаж өмнөх феодал эздийн зарц байсан тариачид өөрийн гэсэн газартай болсон.
- 2) Шинэ газруудыг тариаланд ашиглахаас гадна шим тэжээл буурсан газруудын ашиглалтыг улам нэмэгдүүлсэн.
- 3) Зүүн, баруун Европын бүх улсууд тахлын аюулд өртсөн.
- 4) 400-1400 он хүртэл дэлхийн цар уур тогтмол сэрүүсэж ургац муудсан ба энэ үеийг бага мөстлөгийн үе гэж нэрлэдэг.
- 5) Хүн ам эрс цөөрснөөр тариалангийн газрын ашиглалт буурч үр тарианы үнэ өссөн.
- 6) Ажилчдын тоо цөөрсөн тул цалин буурах шалтгаан болсон.
- 7) Газрын үнэ буурахад хөдөө аж ахуйн бус барааны үнэ өссөн.
- 8) Дундад зууны үеийн суурин хотуудын хүн ам, хөдөөний хүн амаас ихээр цөөрсөн.
- 9) Жижиг суурингууд олноор устаж үгүй болсон бол томоохон хотууд хэмжээний хувьд жижгэрсэн.
- 10) 15-р зуунд үр тарианы үнэ өсөж, буурах хэлбэлзэж байхгүй байсан.
- 11) Бяслаг, үхрийн махны үнэ харьцангуй буурсан.

ОЛОН СОНГОЛТТОЙ ТЕСТ

- 1) Хүн ам ихээр хорогдсон зарим газруудад хөдөө аж ахуйн ажилчны цалин _____
 a) 10-20 хувиар нэмэгдсэн.
 b) 30-40 хувиар нэмэгдсэн.
 c) 40-50 хувиар нэмэгдсэн.
 d) 40-50 хувиар нэмэгдэж 15-р зууны турш амь зуулгын түвшинд байсан.
- 2) Ажилчдыг хөлсөлж ажлуулах газрын эзэд _____
 a) амь зуулгын түвшний цалинг өгөх шаардлагатай болсон.
 b) түрээс, татвар, ажлын хөлс гэсэн тогтмол зардалтай байсан.
 c) илүү ашиг олохын тулд илүү багаар тариалахаас өөр арга байгаагүй.
- 3) Тариалан эрхэлдэг эзэд илүү ашиг олохоор _____ үйлдвэрлэх болсон.
 a) Мал аж ахуйн бүтээгдэхүүн, үхрийн тэжээл
 b) хүнсний ногоо, вино
 c) хонины ноос
 d) Дээрх хариултууд бүгд зөв.

- 4) Хөдөө аж ахуйн бараа олон янз болсноор илүү шим тэжээлтэй хүнс хэрэглэх болсон.
 a) Үнэн.
 b) Худал.
- 5) Үр тарианы үйлдвэрлэлээс хүнсний ногооны үйлдвэрлэлд шилжиж цааш Америк, Австрали тивүүдэд түгсэн.
 a) Үнэн.
 b) Худал.
- 6) Хар Үхэл болон хүн амын хямралаас үүдэн нийгэм ихээхэн өөрчлөгдсөн ба боолуудын эрх, эрх чөлөө чухал байхаа больсон.
 a) Үнэн.
 b) Худал.
- 7) Тариалангийн ажилчдын цалин буурсан тул газрын эзэд газраа тэдэнд ихээр түрээслүүлэх болсон.
 a) Үнэн.
 b) Худал.
- 8) Феодалын хамжлагат нийгмийг халах эхлэл болсон.
 a) Үнэн.
 b) Худал.
- 9) Феодал эзэд цалинг царцааж хамжлагат тариачдыг бага хөлсөөр ажиллуулахыг хичээдэг байсан ч хөдөлмөрийн хомсдолоос болж ажилчид илүү эрх мэдэлтэй болсон.
 a) Үнэн.
 b) Худал.
- 10) Ажилчид _____, _____-ийн илүү сайн нөхцлийг эздээс шаардах байр сууринд байв.
 a) өндөр цалин, илүү капитал
 b) түрээс, эрх чөлөө
 c) амь зуулгын цалин, ажлын сайн нөхцөл
 d) Дээрх хариулт бүгд зөв
- 11) Бага түрээс, илүү сайн нөхцөл, эрх чөлөөг олгохгүй бол бослого, үймээн ихээр дэгдэх болсон.
 a) Үнэн.
 b) Худал.
- 12) _____ онд Францын хойд хэсэгт тариачдын _____ бослого гарсан.
 a) 1356, Фрэнк
 b) 1357, Жэк
 c) 1368, Жон
 d) Дээрх хариулт бүгт буруу

1358, Jacquerie

- 13) Шинэ тив, эх газрын нээлтүүд хийгдэж Хар Үхэл нийгмийн өөрчлөлтийг эхлүүлж, хөдөө аж ахуй, мал аж ахуйн үйлдвэрлэлийг ихээхэн өөрчилсөн.
a) Үнэн.
b) Худал.
- 14) Хот суурин газруудын хувьд Хар Үхэл тахал дэгдэхээс өмнө ариун цэвэр муу, бохирдол багатай, дайн үймээн, хүнсний хомсдол зэргээс болон нас баралтын хувь төрөлтийн хувиас үргэлж дээгүүр байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 15) Хар Үхэл тахлаас хойш хөдөө амьд үлдэгсэд илүү _____, _____-ийг хайж хот руу ихээр нүүн суурьших болсон.
a) хоол хүнс, амь зуулга
b) цалин хөлс, зах зээл
c) Дээрх хариулт бүгд зөв.
- 16) Хөдөөний үйлдвэрлэгчид _____ хот суурин руу нүүх шилжилтийг улам нэмэгдүүлсэн.
a) мал аж ахуйд ихээр шилжсэнээр
b) газрын ашиглалтыг бууруулснаар
c) Дээрх хариулт бүгд зөв.
- 17) Газар тариалантай харьцуулахад мал аж ахуй хөдөлмөр _____ шаарддаг.
a) их
b) бага
c) Дээрх хариулт бүгд буруу
- 18) Хотод илүү ур чадвартай ажилчдын хэрэгцээ байдаг.
a) Үнэн.
b) Худал.
- 19) Томоохон хот руу нүүн ирэх хүмүүс ихэвчлэн хөдөөний тариаланчид байв.
a) Үнэн.
b) Худал.
- 20) Зарим хотуудад гаднаас шинээр ирэгсэдийн 30-аас илүү хувь тариаланчид байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 21) Алс худалдаа хийдэг хотуудад ирэгсэдийн талаас илүү хувь худалдаачид, гар урчууд байсан.
a) Үнэн.
b) Худал.

- 22) Улсын иргэншил _____ зэргийг олгодог.
a) сонгох, сонгогдох улс төрийн эрх
b) төрийн хамгаалалтанд байх
c) татварын хөнгөлөлт
d) Дээрх хариулт бүгд зөв.
- 23) Тухайн үед хот суурин газрууд иргэншил олгодоггүй байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 24) Улс төрийн эрх, заримдаа худалдааг хязгаарласан эдийн засгийн давуу талыг иргэдэд олгодог байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 25) Хөдөөний хамжлагат ардууд хотын иргэн болоход бэрхшээлтэй байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 26) Тахлаас хойш хагас зууны дараа хотын иргэд, шинээр нүүн ирэгсэд, байнгын оршин суугчид хотын нийгэмд томоохон, давамгайлах шинжтэй нийгэмлэгүүд болж ирсэн.
a) Үнэн.
b) Худал.
- 27) Эдгээр нийгэмлэгүүдийн хооронд өрсөлдөөн, маргаан харьцангуй бага тохиолдсон.
a) Үнэн.
b) Худал.
- 28) 14-15-р зуунд Англи, Францын 100 жилийн дайныг санхүүжүүлэхээр Францын хааны гаргасан татварыг эсэргүүцсэн бослого гарсан.
a) Үнэн.
b) Худал.
- 29) Хамгийн алдартай бослого 1378 онд Италийн Флоренц хотонд болсон Ciompi бослого байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 30) Даавууны үйлдвэрийн ажилчид өөрсдийн цалин нэмэхийг шаардаж, мөн тэдний улс төрийн оролцоог нэмэгдүүлж өгөхийг шаардсан бослого байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 31) Бослогын хүрээнд шаардаж байсан зүйл аль вэ?
a) доод ажилчдын нэгдэл бий болгох, өртэй хүмүүсийг баривчлахыг зогсоох

- b) хүчээр зээл өгөхийг болиулах, үр тарианы үнийг бууруулах
c) даавууны үйлдвэрлэлийн хэмжээг тэнцвэржүүлэх квот тогтоох
d) Дээрх хариулт бүгд зөв.
- 32) Бослого бүрэн амжилтанд хүрсэн.
a) Үнэн.
b) Худал.
- 33) Европын хотуудад олон тооны бослогууд гарсан ба хотын удирдлагын шийдвэр гаргалтанд нэгдлүүдийг оролцуулахыг шаардсан тайван жагсаал цуглаан дийлэнх байжээ.
a) Үнэн.
b) Худал.
- 34) Ядуус болон язгууртнуудын нэгдэл шийдвэр гаргалтанд ихээр оролцох болсон.
a) Үнэн.
b) Худал.
- 35) Гэвч ядуу ажилчдын нэгдэл зохион байгуулалт муутай байсан тул төдийлөн амжилтанд хүрэхгүй, язгууртан, худалдаачин, баячуудын нэгдэл шийдвэр гаргалтанд ихээр оролцох болсон.
a) Үнэн.
b) Худал.
- 36) Бослогын бодит үр өгөөжийг хотын ядуус хүртэж Европ даяар цалин нэмэгдэж буй нөхцөл байдалд хамгийн эрэлттэй олон төрлийн бараануудыг үйлдвэрлэх, худалдаалах болсон.
a) Үнэн.
b) Худал.
- 37) 14-р зууны эдийн засгийн бодлого өөрийн хотын бараа, бүтээгдэхүүнийг бусад хотын өрсөлдөөнөөс хамгаалахад чиглэж байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 38) Ихэвчлэн язгууртнуудыг хамгаалсан эдийн засгийн бодлогууд монопол, онцгой эрхтэй, гадны худалдаачдыг эсэргүүцсэн шинжтэй байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 39) Хар Үхэл тахлаас хойш үүссэн дүрэм журам хэт нарийн, тодорхой, protectionist агуулгагүй байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 40) Томоохон хотуудын байр суурь суларч эдийн засгийн хувьд муудаж ирсэн.
a) Үнэн.

b) Худал.

- 41) Хотын зөвлөлүүд нэгдэл болон худалдаачдад монопол эрх олгож байсан бол бүсийн лордууд хотуудад монопол эрх, хааны засгийн газар илүү их газар нутаг хамарсан бүс нутагт хураамж авах, худалдаа эрхлэх зэрэгт монопол эрх олгосон.
a) Үнэн.
b) Худал.
- 42) 14-р зуунд гар урчуудын нэгдэл тодорхой барааг үйлдвэрлэх монопол эрх авч тухайн нэгдэлд элсэхийг хязгаарлах, чанарын хяналт бий болгох, материалын стандарт, доод үнийг тогтоох зэрэг арга хэмжээ авч байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 43) Гадны худалдаачид аливаа жижиглэнгийн худалдаа хийж болох ч бусад гадны худалдаачинтай наймаа хийхийг зөвшөөрдөггүй байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 44) Бүх хотууд хэт хамгаалсан бодлого явуулснаар тэдний гадаад худалдаа зогсонги байдалд орж эхэлсэн ба өөрийн худалдаачдыг дэмжихийн тулд дүрэм, журмыг сулруулахаас өөр аргагүй болсон.
a) Үнэн.
b) Худал.
- 45) Тиймээс гадаад худалдааны гэрээг харилцан хийж, харилцан худалдааны давуу талыг тохиролцох болжээ.
a) Үнэн.
b) Худал.
- 46) Тиймээс гадаад худалдааны гэрээг харилцан хийж, харилцан худалдааны давуу талыг тохиролцох болжээ.
a) Үнэн.
b) Худал.

ТОВЧ ХАРИУЛТТАЙ АСУУЛТ

- 1) Хар Үхэл тахлын дараа Европын эдийн засгийн бүтцэд гарсан өөрчлөлтийн талаар ярилцана уу.
- 2) Хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийн талаар хэлэлцэнэ үү.
- 3) Феодалын нийгэмд гарсан өөрчлөлтүүд юу байсан бэ?
- 4) Хотжилтийг эрчимжүүлсэн шалтгааны талаар ярилцана уу.
- 5) Протекционист болон монопол бодлогын талаар ярилцана уу.

ҮНЭН ЭСВЭЛ ХУДАЛ ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛЖ, ТАЙЛБАР ХИЙНЭ ҮҮ.

Аж үйлдвэрийн хувьсгал ба даавууны үйлдвэрлэл

- 1) Аж үйлдвэрийн хувьсгал 18-р зууны дундуур Их Британи, Нидерланд улсуудад эхэлсэн.
- 2) Аж үйлдвэрийн хувьсгал эхэлсэн шалтгааныг ойлгоход дундад зууны үеийн Английн үйлдвэрлэгчдэд тулгарч байсан асуудлуудыг авч үзэх шаардлагатай.
- 3) Их Британийн нэхмэлийн үйлдвэрлэл олон зууны турш хонины ноос ашигласан.
- 4) Англи ноос зөвхөн дотоодод эрэлттэй байсан ба чанарын хувьд хамгийн сайнд тооцогдож нэхмэлчид өндөр үнэ төлдөг байсан.
- 5) Английн нэхмэлчид дотоодын хэрэглээгээ бүрэн хангаж, Европын бусад худалдааны бүсүүд рүү экспортолдог байсан.
- 6) Дундад зууны нэгдлүүд ноосон даавууны үйлдвэрлэл болон худалдааг хяналтандаа төдийлөн байлгаагүй.
- 7) Английн хаант төрөөс бүх үйлдвэрлэлийг дэмжиж холбогдох хуулиудыг батлан гаргаж, хэрэгжүүлж байв.
- 8) 14-15-р зуунд Английн эдийн засаг даавууны үйлдвэрлэл дээр тогтож байсан гэж үздэг.
- 9) 1550-аад онд Европын бусад улсуудын ижил Англи улс мөн олон улсын худалдаанд ихээр оролцох болсон.
- 10) Худалдааны хэмжээ нэмэгдсэнээр Англи руу импортлогдох барааны хэмжээ буурсан.
- 11) Зөвхөн халуун ногоо, элсэн чихэр, кофе, цай импортлох болсон.
- 12) Англичууд Хятадын шаазан эдлэлийн импортыг нэмэгдүүлсэн.

ОЛОН СОНГОЛТТОЙ ТЕСТ

- 1) Импортын бараанууд дунд Азийн _____ чухал байр суурийг эзэлсэн.
 - a) шаазан эдлэл
 - b) халуун ногоо
 - c) цай
 - d) Дээрх хариулт бүгд буруу.
- 2) Хөвөн даавууны гол нийлүүлэгч _____ байсан.
 - a) Хятад
 - b) Перс
 - c) Энэтхэг
 - d) Дээрх хариулт бүгд буруу.
- 3) Импортлоор орж ирсэн хөвөн даавуу эхлээд хэрэглэгчдэд таалагдаагүй.

- a) Үнэн.
- b) Худал.

- 4) Импортын хөвөн даавуу ноосон даавуу ижил чанартай, будганд орох боломжтой зэрэг даавуу талуудтай.
 - a) Үнэн.
 - b) Худал.
- 5) Таашаал өөрчлөгдөхөд ноосон даавуу үйлдвэрлэгчдэд хүндээр туссан.
 - a) Үнэн.
 - b) Худал.
- 6) Тиймээс 17-р зууны сүүл үеэс эхлэн Английн ноосон даавуу үйлдвэрлэгчид хөвөн даавууны нэхмэл, будагтай бүтээгдэхүүний импортлох хэмжээг хязгаарлах арга хэмжээнүүдийг авч эхэлсэн.
 - a) Үнэн.
 - b) Худал.
- 7) Ноосон даавуу үйлдвэрлэгчид эвлэл, нэгдлийн зохион байгуулалттай байсан ч төдийлөн нөлөөгүй байсан.
 - a) Үнэн.
 - b) Худал.
- 8) _____ эхэн үедээ хөвөн даавууны импортыг ихээр хязгаарлаж чадсан.
 - a) Импортлогчид
 - b) Үйлдвэрлэгчид
 - c) Нэгдлүүд
 - d) Дээрх хариулт бүгд буруу
- 9) 18-р зууны эхэн үед Английн парламент дотоодын зах зээлд хамгийн эрэлттэй _____ хөвөн даавууны импортыг хориглосон хууль баталж, хэрэгжүүлсэн.
 - a) Энэтхэг
 - b) Хятад
 - c) Перс
 - d) Дээрх хариулт бүгд зөв.
- 10) Дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ, импортын хөвөн даавуу нийлээд нийт эрэлтийг хангаж чадахгүй байсан.
 - a) Үнэн.
 - b) Худал.
- 11) Энтрепренерүүд хөвөн даавууг багахан импортлоход Англид эрэлтийг өсгөх боломжийг харсан.
 - a) Үнэн.
 - b) Худал.

- 12) Их Британид 18-р зууны эхэн үед ноосон үйлдвэрлэлээс хөвөн үйлдвэрлэлд шилжих үйл явц эхлээгүй байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 13) Ноосон үйлдвэрлэл эрхлэгчид, баян давхаргынхан хамгаалах, хязгаарлах, хориглох бодлого, арга хэмжээг ихээхэн авч байсан ч зарим _____ шилжилтийг манлайлах болсон.
a) хөвөн импортлогчид
b) нэгдлүүд
c) энтрепренерүүд
d) Дээрх хариулт бүгд зөв.
- 14) Английн нэхмэл эдлэл үйлдвэрлэгчид _____ гэсэн сорилттой тулсан.
a) үйлдвэрлэлийн зохион байгуулалт, чанар
b) үйлдвэрлэлийн зардал, хурд
c) үйлдвэрлэлийн хурд, технологи
d) Дээрх хариулт бүгд буруу.
- 15) Англид 1500-1750 он хүртэл ноосон даавууг гэр бүлийн хүрээнд нэхмэлчид, жижиг дунд үйлдвэрүүд үйлдвэрлэдэг байжээ.
a) 400-1400
b) 1400-1650
c) 1500-1750
d) Дээрх хариулт бүгд буруу.
- 16) Нэхмэлчин цөөн бүс нутагт хэрэглэгчдийн хэрэгцээг амархан хангадаггүй байжээ.
a) Үнэн.
b) Худал.
- 17) Илүүдэл хэсгийг худалдаачид хүн ам багатай бүс нутгаас хүн ам ихтэй бүс нутагт хүргэж ялангуяа бөөний худалдаа эрхэлж экспортлогчдод нийлүүлдэг байжээ.
a) Үнэн.
b) Худал.
- 18) Аж үйлдвэрийн хувьсгал уурын хөдөлгүүр, эрчим хүчний шинэ эх үүсвэрийн үр дүнд үүссэн гэж үздэг.
a) Үнэн.
b) Худал.
- 19) Ноосон даавуун үйлдвэрлэл явуулахад _____ -ыг бүрэн ашиглахын тулд _____ -ыг нэмэх зайлшгүй шаардлагатай байсан.
a) ороогчдын бүтээмж, нэхмэлчдийн хурд
b) нэхмэлчдийн бүтээмж, ороогчдын хурд
c) нэхмэлчдийн бүтээмж, ороогчдын тоо

d) Дээрх хариулт бүгд зөв.

- 20) Англид хөвөн даавуу болон утасны импортыг хориглосон.
a) Үнэн.
b) Худал.
- 21) Хөвөн утсыг импортолж дотооддоо даавуу үйлдвэрлэхэд Азийн чанарт хүрэхгүй байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 22) Хангалттай утас ээрэх үйлдвэрлэлийн боломжгүй, ээрсэн утасны чанар хүртэл муу байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 23) Ноосон эдлэл үйлдвэрлэлийг нэгдлүүд хяналтандаа байлгадаг байсан учир инновацлаг бүтээгдэхүүн гарах боломжтой байсан.
a) Үнэн.
b) Худал.
- 24) _____ онд нэхмэлч, зохион бүтээгч Жон Кэй нэхмэлийн хурдыг нэмэгдүүлэх санааг дэвшүүлсэн.
a) 1723
b) 1733
c) 1743
d) 1753
- 25) Fly Shuttle нь нэхмэлийн машины _____ нэхэх процессыг автоматжуулсан.
a) уртаар
b) богиноор
c) хөндлөн
d) урагшаа
- 26) Fly Shuttle нэхэх хурдыг нэмэгдүүлсэн ч даавууны хэмжээнд нөлөөлөөгүй.
a) Үнэн.
b) Худал.
- 27) Жон Кэй Англиас зугтаж _____ дүрвэн гарч амьдарсан.
a) Нидерландад
b) Францад
c) Энэтхэгт
d) Монголд
- 28) Нэг нэхмэлийн машиныг 6 ажилчин ажиллуулдаг байсныг Жон Кэйгийн Fly Shuttle дангаараа хийх болсон?
a) 2 ажилчин
b) 5 ажилчин

true

c) 10 ажилчин

d) Дээрх хариулт бүгд буруу.

29) Нэхмэлийн хурд эрс нэмэгдсэн нь утас бэлтгэх дамжлагыг илүү удаан болгож харагдуулах болсон.

a) Үнэн.

b) Худал.

30) Утасны нийлүүлэлт ихээр нэмэгдэж үнэ огцом өсөж бэлэн нэхмэлийн утас ховордож эхэлсэн.

a) Үнэн.

b) Худал.

31) _____ төмрийн зорогч машиныг бүтээж 1732 онд _____ гэдэг хүнд патентаа худалдсан.

a) Lewis Wyatt, John Paul

b) John Wyatt, Lewis Paul

32) _____ онд John Wyatt хүний оролцоогүй утас ээрэх машиныг бүтээж, туршилтыг хийсэн.

a) 1732

b) 1742

c) 1752

d) 1762

33) Spinning machine олон талаар маш чухал байсан – хүний хурууны чимхэх даралттай ижил байх, орц гарцыг тохируулан үйлдвэрлэх, эрчим хүчний тохиромжтой хэрэглээтэй байх гэх мэт.

a) Үнэн.

b) Худал.

34) 1738 онд ээрэгч машины патентыг _____ эзэмших болсон.

a) John Wyatt

b) Lewis Paul

35) Эд ангиуд нарийн төвөгтэй, байнгын тохиргоо хийж ажиллуулах байсан учир ээрэх салбарын хүмүүст төдийлөн хүрч чадаагүй.

a) Үнэн.

b) Худал.

36) Spinning machine бүтээгдсэнээс хойш 35 жилийн дараа James Hargreaves илүү сайжруулсан ээрэгч машин бүтээсэн.

a) Үнэн.

b) Худал.

37) James Hargreaves илүү сайжруулсан автомат машин бүтээсэн.

a) Үнэн.

b) Худал.

38) Аж үйлдвэрийн хувьсгалын нэгэн чухал хүчин зүйл бол хөдөлмөрийн зохион байгуулалтыг үйлдвэрийн системд шилжүүлсэн явдал байсан.

a) Үнэн.

b) Худал.

39) Richard Arkwright үсчин байсан ба усан тээрмийн технологийг утас нэхэх нэвтрүүлсэн.

a) Үнэн.

b) Худал.

40) Richard Arkwright _____ нэртэй машиныг бүтээсэн.

a) Steam Frame

b) Water Frame

41) Spinning jenny эрчим хүчний тогтмол эх үүсвэр ашиглах тул Spinning machine-аас ялгаатай байсан.

a) Үнэн.

b) Худал.

ТОВЧ ХАРИУЛТТАЙ АСУУЛТ

- 1) Аж үйлдвэрийн хувьсгалын өмнө ба дараах үйлдвэрийн системийн талаар тайлбарлана уу.
- 2) Нэхмэл болон ээрэгч автомат машины үүслийн ач холбогдлын талаар хэлэлцэнэ үү.
- 3) “Аж үйлдвэржилтийг үндсээр нь эхлүүлсэн нээлт бол уурын хөдөлгүүр юм” гэсэн санааг тайлбарлана уу.
- 4) Аж үйлдвэрийн хувьсгалаас өмнө ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэл Английн эдийн засагт яагаад хамгийн чухал салбар байсан талаар хэлэлцэнэ үү.
- 5) Старт-ап компаниуд инновацийг хэрхэн бий болгодог талаар ярилцана уу.